

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны  
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/327/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 51-261628 Цахим хаяг: <a href="mailto:natsagdorjs@audit.gov.mn">natsagdorjs@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ Утас:51-261628 Цахим хаяг: <a href="mailto:baterdenee@audit.gov.mn">baterdenee@audit.gov.mn</a></p> <p>Аудитор:Б.Батхишиг Утас:51-261628 Цахим хаяг: <a href="mailto:batkhashigb@audit.gov.mn">batkhashigb@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>3</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....</b>	<b>12</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН .....</b>	<b>19</b>
4.1 Ерөнхий зүйл .....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	22
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>23</b>
5.1 Төлбөрийн акт.....	23
5.2 Албан шаардлага.....	24
5.3 Зөвлөмж .....	25
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>26</b>

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
САГ	Санхүүгийн аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/351

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 156,802.1 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг нарийвчлан төлөвлөөгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 11 бараа, ажил, үйлчилгээг 149,829.5 мянган төгрөгөөр худалдан авсан;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж бэлэг, дурсгалын зүйлсэд 4,720.0 мянган төгрөгийг зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.4, 41 дүгээр зүйлийн 41.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын шүүхийн тухай хуульд бүх шатны шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн чуулганыг хоёр жил тутам зохион байгуулна гэж заасны дагуу тайлант онд “Нийт шүүгчийн III чуулган”-ыг зохион байгуулж, 15,031.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 975,400.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 2,514,575.3 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 16,054.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшил, 10,970,953.0 мянган төгрөгийн программ хангамж, 17,707.6 мянган төгрөгийн бараа материал, нийт 14,494,690.3 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, санхүүгийн тайланд тусгасан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3,069,000.0 мянган төгрөгийн дансны үнэтэй барилгыг газрын хамт Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд балансаас балансад шилжүүлэхээр 2025 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр холбогдох эрх бүхий байгууллагад хүсэлт хүргүүлсэн байна.

## **Бусад асуудал**

Тайланд онд “Шүүхийн үйлчилгээний стандарт”-ын төслийг анх удаа шинээр боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 40 дүгээр тогтоолоор батлуулан Стандарт, хэмжил зүйн газарт байгууллагын стандартаар бүртгүүлжээ. Энэхүү стандарт нь шүүхийн захиргааны байгууллагаас үзүүлэх үйлчилгээний төрөл, арга, хэлбэрийг тодорхойлж, шүүхийн ажилтны харилцаа, хандлага, ур чадварын нийтлэг шаардлагыг тогтоосон байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>407,740,926.72</b>	<b>393,902,805.03</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,088,101.00</b>	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,088,101.00	-
31210	Төгрөг	1,088,101.00	-
31211	Төрийн сангийн харилцах	1,088,101.00	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	<b>1,968,536.65</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	880,435.65
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,088,101.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>9,539,656.67</b>	<b>9,400,982.33</b>
34600	Урьдчилж гарсан зардал	9,539,656.67	9,400,982.33
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>397,113,169.05</b>	<b>382,533,286.05</b>
35400	Хангамжийн материал	397,113,169.05	382,533,286.05
35410	Бичиг хэргийн материал	18,461,329.00	15,483,499.00
35420	Аж ахуйн материал	317,727,377.05	332,087,624.05
35430	Сэлбэг хэрэгсэл	42,452,300.00	29,245,000.00
35440	Түлш, шатах тослох материал	10,585,000.00	2,575,000.00
35470	Бусад хангамжийн материал	7,887,163.00	3,142,163.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,160,915,260.66</b>	<b>26,333,111,050.26</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,160,915,260.66	26,333,111,050.26
39200	Биет хөрөнгө	10,862,481,947.75	13,203,251,937.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,271,310,987.50	9,271,310,987.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,299,432,249.17)	(1,514,514,139.13)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	707,046,000.00	1,421,986,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(182,613,444.56)	(219,227,666.76)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,802,561,397.73	5,924,596,647.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,900,528,699.10)	(2,123,701,795.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	596,872,492.92	594,108,815.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	(221,144,300.21)	(238,956,060.68)
39214	Бусад үндсэн хөрөнгө	51,748,840.00	46,990,040.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,832,404.48)	(19,834,217.88)
39217	Ном	60,493,327.12	60,493,327.12
39300	Биет бус хөрөнгө	2,298,433,312.91	13,129,859,112.56
39301	Программ хангамж	570,433,556.00	11,587,575,118.25
39302	Хуримтлагдсан элэгдэл	(153,177,099.13)	(337,157,852.77)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,882,911,865.00	1,882,911,865.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,735,008.96)	(3,470,017.92)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>13,568,656,187.38</b>	<b>26,727,013,855.29</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,530,882.00</b>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,530,882.00	-
41300	Өглөг	2,530,882.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,530,882.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,566,125,305.38</b>	<b>26,727,013,855.29</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	13,566,125,305.38	26,727,013,855.29
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,646,495,144.95	2,646,495,144.95
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	2,646,495,144.95	2,646,495,144.95
51200	Хуримтлагдсан үр дүн	8,275,326,173.76	21,466,916,605.76
51210	Өмнөх үеийн үр дүн	7,659,692,487.25	8,306,028,055.85
51220	Тайлант үеийн үр дүн	615,633,686.51	13,160,888,549.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,644,303,986.67	2,613,602,104.58
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>13,568,656,187.38</b>	<b>26,727,013,855.29</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>10,114,304,101.50</b>	<b>26,694,344,692.57</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,885,482,081.50</b>	<b>14,930,781,979.82</b>
120	Нийтлэг татварын бус орлого	1,885,482,081.50	14,930,781,979.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	460,616,786.38	155,487,886.67
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,616,786.38	155,487,886.67
120009	Бусад орлого	1,368,600.00	658,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,407,310,965.12	14,749,975,183.15
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,185,730.00	24,660,910.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>11,763,562,712.75</b>
1221	Хандив тусламж/дотоод/	-	11,763,562,712.75
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	11,747,952,432.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	11,747,952,432.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,610,280.75
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15,610,280.75
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>8,228,822,020.00</b>	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,210,017,860.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,210,017,860.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,804,160.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,934,783.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,869,377.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,476,176,345.67</b>	<b>13,398,078,261.53</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,476,176,345.67</b>	<b>13,398,078,261.53</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>8,761,607,176.24</b>	<b>12,872,124,307.63</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5,366,638,410.80</b>	<b>8,477,742,347.38</b>
210101	Үндсэн цалин	3,237,278,329.88	4,706,322,359.23
210102	Нэмэгдэл	1,064,977,142.40	1,773,472,838.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	700,293,687.70	1,169,661,335.49
210104	Урамшуулал	364,089,250.82	828,285,814.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>674,591,499.76</b>	<b>1,063,181,543.05</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	462,610,272.05	725,006,182.16
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	54,418,438.59	86,870,568.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	28,316,820.63	46,393,289.13
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	25,299,080.65	43,189,709.93
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	103,946,887.84	161,721,793.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>324,468,985.29</b>	<b>489,296,296.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	57,875,660.69	90,536,895.93
210302	Түлш, халаалт	11,011,349.58	10,815,215.04
210303	Цэвэр, бохир ус	13,010,675.02	13,524,835.28
210304	Байрны түрээс	242,571,300.00	374,419,350.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>603,920,376.80</b>	<b>552,481,556.02</b>
210401	Бичиг хэрэг	176,174,840.00	106,464,970.00
210402	Тээвэр, шатахуун	80,801,000.00	85,762,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,894,375.70	41,759,150.02
210404	Ном, хэвлэл	292,500.00	-

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,711,385.00	701,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	265,163,230.00	300,761,855.00
210408	Бараа материал акталсны зардал	39,083,046.10	16,312,581.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>148,753,859.00</b>	<b>65,237,200.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,160,900.00	-
210604	Урсгал засвар	120,592,959.00	65,237,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>149,463,736.95</b>	<b>192,292,370.00</b>
210701	Гадаад албан томилолт	92,839,026.95	124,814,070.00
210702	Дотоод албан томилолт	56,624,710.00	67,478,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>327,798,164.69</b>	<b>307,509,947.51</b>
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	294,478,384.36	247,737,925.17
210803	Даатгалын үйлчилгээ	7,874,313.33	11,992,965.34
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,406,512.00	7,112,462.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	196,000.00	697,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,305,160.00	21,431,800.00
210807	Газрын төлбөр	18,537,795.00	18,537,795.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,165,972,142.95</b>	<b>1,724,383,047.42</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	116,973,100.00	57,681,200.00
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	100,409,900.00	137,946,280.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	948,589,142.95	1,528,755,567.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>714,569,169.43</b>	<b>525,953,953.90</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	<b>457,452,757.88</b>
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	<b>457,452,757.88</b>
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	<b>457,452,757.88</b>
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	287,738,465.46
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	13,568,405.75
2131123	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	156,145,886.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,869,260.00	68,501,196.02
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,017,260.00	18,644,236.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	51,852,000.00	49,856,960.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	599,699,909.43	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	599,265,036.43	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	434,873.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>638,127,755.83</b>	<b>13,296,266,431.04</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>22,494,069.32</b>	<b>135,377,881.13</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	448,432.68	-
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	21,297,636.64	117,883,981.13
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	748,000.00	17,493,900.00
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(22,494,069.32)</b>	<b>(135,377,881.13)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>615,633,686.51</b>	<b>13,160,888,549.91</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>8,689,438,806.38</b>	<b>11,919,708,599.42</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>460,616,786.38</b>	<b>156,145,886.67</b>
120	Нийтлэг татварын бус орлого	460,616,786.38	156,145,886.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	460,616,786.38	155,487,886.67
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	460,616,786.38	155,487,886.67
120009	Бусад орлого	-	658,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>-</b>	<b>11,763,562,712.75</b>
1221	Хандив тусламж/дотоод/	-	11,763,562,712.75
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	11,747,952,432.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	11,747,952,432.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,610,280.75
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15,610,280.75
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>8,228,822,020.00</b>	<b>-</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,210,017,860.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,210,017,860.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,804,160.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,934,783.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,869,377.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>8,522,393,146.38</b>	<b>11,851,936,545.42</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>8,522,393,146.38</b>	<b>11,851,936,545.42</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>7,803,100,722.95</b>	<b>11,320,272,999.52</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>5,341,730,928.80</b>	<b>8,480,273,229.38</b>
210101	Үндсэн цалин	3,212,370,847.88	4,706,322,359.23
210102	Нэмэгдэл	1,064,977,142.40	1,773,472,838.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	700,293,687.70	1,169,661,335.49
210104	Урамшуулал	364,089,250.82	830,816,696.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>674,987,939.85</b>	<b>1,064,061,978.70</b>
210201	Тэтгэврийн даатгалын зардал	463,006,712.14	725,886,617.81
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	54,418,438.59	86,870,568.73
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	28,316,820.63	46,393,289.13
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	25,299,080.65	43,189,709.93
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	103,946,887.84	161,721,793.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>324,468,985.29</b>	<b>489,296,296.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	57,875,660.69	90,536,895.93
210302	Түлш, халаалт	11,011,349.58	10,815,215.04
210303	Цэвэр, бохир ус	13,010,675.02	13,524,835.28
210304	Байрны түрээс	242,571,300.00	374,419,350.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>323,494,197.70</b>	<b>312,658,141.02</b>
210401	Бичиг хэрэг	67,118,950.00	71,034,140.00
210402	Тээвэр, шатахуун	69,800,000.00	60,418,097.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	28,894,375.70	41,759,150.02
210404	Ном, хэвлэл	9,492,500.00	2,573,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,800,000.00	720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	146,388,372.00	136,153,754.00

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,829,500.00</b>	<b>1,078,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,829,500.00	1,078,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>262,878,433.00</b>	<b>114,767,450.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,312,180.00	18,619,700.00
210602	Тавилга	-	-
210604	Урсгал засвар	245,566,253.00	96,147,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>166,148,736.95</b>	<b>211,139,273.00</b>
210701	Гадаад албан томилолт	98,434,026.95	128,214,070.00
210702	Дотоод албан томилолт	67,714,710.00	82,925,203.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>364,684,571.36</b>	<b>352,785,773.17</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	328,177,634.36	286,799,925.17
210803	Даатгалын үйлчилгээ	11,061,470.00	17,081,791.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,406,512.00	7,112,462.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	196,000.00	697,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,305,160.00	22,556,800.00
210807	Газрын төлбөр	18,537,795.00	18,537,795.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>336,877,430.00</b>	<b>294,212,858.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	206,767,111.00	108,153,412.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,110,319.00	186,059,446.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>719,292,423.43</b>	<b>531,663,545.90</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>457,452,757.88</b>
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	457,452,757.88
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	457,452,757.88
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	287,738,465.46
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	13,568,405.75
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	156,145,886.67
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>119,592,514.00</b>	<b>73,122,687.02</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	6,604,130.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,017,260.00	18,644,236.02
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	56,575,254.00	47,874,321.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>599,699,909.43</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	599,265,036.43	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	434,873.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,088,101.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,088,101.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>167,045,660.00</b>	<b>67,772,054.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>167,045,660.00</b>	<b>68,860,155.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	167,045,660.00	68,860,155.00
2200	Дотоод эх үүсвэрээр	167,045,660.00	68,860,155.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	167,045,660.00	68,860,155.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(167,045,660.00)	(68,860,155.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	(1,088,101.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,088,101.00	1,088,101.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,088,101.00	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,659,692,487.25	12,950,491,618.87
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	7,659,692,487.25	12,950,491,618.87
9	Тайлант үеийн үр дүн	-	-	615,633,686.51	615,633,686.51
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	8,275,326,173.76	13,566,125,305.38
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	30,701,882.09	30,701,882.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,646,495,144.95	2,644,303,986.67	8,306,028,055.85	13,596,827,187.47
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(30,701,882.09)	-	(30,701,882.09)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	13,160,888,549.91	13,160,888,549.91
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,646,495,144.95	2,613,602,104.58	21,466,916,605.76	26,727,013,855.29

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>13,887,486,900.00</b>	<b>11,460,213,966.54</b>	<b>2,427,272,933.46</b>	<b>82.5</b>
12	Татварын бус орлого	13,887,486,900.00	155,487,886.67	13,731,999,013.33	1.1
120	Нийтлэг татварын бус орлого	510,000,000.00	155,487,886.67	354,512,113.33	30.5
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	510,000,000.00	155,487,886.67	354,512,113.33	30.5
122	Тусламжийн орлого	13,377,486,900.00	11,304,726,079.87	2,072,760,820.13	84.5
122005	Төсвөөс санхүүжих	13,377,486,900.00	11,304,726,079.87	2,072,760,820.13	84.5
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,887,486,900.00</b>	<b>11,460,213,966.54</b>	<b>2,427,272,933.46</b>	<b>82.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,887,486,900.00</b>	<b>11,460,213,966.54</b>	<b>2,427,272,933.46</b>	<b>82.5</b>

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,361,046,400.00</b>	<b>11,387,091,279.52</b>	<b>1,973,955,120.48</b>	<b>85.2</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>9,278,684,500.00</b>	<b>8,478,458,229.38</b>	<b>800,226,270.62</b>	<b>91.4</b>
210101	Үндсэн цалин	4,704,768,400.00	4,704,507,359.23	261,040.77	100.0
210102	Нэмэгдэл	2,169,219,800.00	1,773,472,838.25	395,746,961.75	81.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,169,740,400.00	1,169,661,335.49	79,064.51	100.0
210104	Урамшуулал	1,234,955,900.00	830,816,696.41	404,139,203.59	67.3
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>1,159,835,500.00</b>	<b>1,063,835,103.70</b>	<b>96,000,396.30</b>	<b>91.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	788,688,200.00	725,659,742.81	63,028,457.19	92.0
210202	Тэтгэмжийн даатгал	92,786,800.00	86,870,568.73	5,916,231.27	93.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	46,393,400.00	46,393,289.13	110.87	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	46,393,400.00	43,189,709.93	3,203,690.07	93.1
210205	Эрүүл мэндийн даатгал	185,573,700.00	161,721,793.10	23,851,906.90	87.1
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>553,743,600.00</b>	<b>489,296,296.25</b>	<b>64,447,303.75</b>	<b>88.4</b>
210301	Гэрэл, цахилгаан	98,066,300.00	90,536,895.93	7,529,404.07	92.3
210302	Түлш, халаалт	32,682,900.00	10,815,215.04	21,867,684.96	33.1
210303	Цэвэр, бохир ус	37,488,900.00	13,524,835.28	23,964,064.72	36.1
210304	Байрны түрээс	385,505,500.00	374,419,350.00	11,086,150.00	97.1
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>480,819,300.00</b>	<b>312,658,141.02</b>	<b>168,161,158.98</b>	<b>65.0</b>
210401	Бичиг хэрэг	156,784,400.00	71,034,140.00	85,750,260.00	45.3
210402	Тээвэр, шатахуун	69,819,300.00	60,418,097.00	9,401,203.00	86.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	44,530,400.00	41,759,150.02	2,771,249.98	93.8
210404	Ном, хэвлэл	12,573,000.00	2,573,000.00	10,000,000.00	20.5
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,520,000.00	720,000.00	1,800,000.00	28.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	194,592,200.00	136,153,754.00	58,438,446.00	70.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>12,968,400.00</b>	<b>1,078,000.00</b>	<b>11,890,400.00</b>	<b>8.3</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,968,400.00	1,078,000.00	11,890,400.00	8.3
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>431,197,000.00</b>	<b>183,627,605.00</b>	<b>247,569,395.00</b>	<b>42.6</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	101,117,100.00	63,740,700.00	37,376,400.00	63.0
210602	Тавилга	61,314,900.00	20,454,355.00	40,860,545.00	33.4
210604	Урсгал засвар	268,765,000.00	99,432,550.00	169,332,450.00	37.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>374,635,700.00</b>	<b>211,139,273.00</b>	<b>163,496,427.00</b>	<b>56.4</b>
210701	Гадаад албан томилолт	145,745,800.00	128,214,070.00	17,531,730.00	88.0
210702	Дотоод албан томилолт	228,889,900.00	82,925,203.00	145,964,697.00	36.2
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>615,226,500.00</b>	<b>352,785,773.17</b>	<b>262,440,726.83</b>	<b>57.3</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	461,845,200.00	286,799,925.17	175,045,274.83	62.1
210803	Даатгалын үйлчилгээ	29,300,000.00	17,081,791.00	12,218,209.00	58.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,112,500.00	7,112,462.00	38.00	100.0

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,722,000.00	697,000.00	4,025,000.00	14.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	84,246,800.00	22,556,800.00	61,690,000.00	26.8
210807	Газрын төлбөр	28,000,000.00	18,537,795.00	9,462,205.00	66.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>453,935,900.00</b>	<b>294,212,858.00</b>	<b>159,723,042.00</b>	<b>64.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	136,910,000.00	108,153,412.00	28,756,588.00	79.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	317,025,900.00	186,059,446.00	130,966,454.00	58.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>526,440,500.00</b>	<b>73,122,687.02</b>	<b>453,317,812.98</b>	<b>13.9</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>526,440,500.00</b>	<b>73,122,687.02</b>	<b>453,317,812.98</b>	<b>13.9</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,500,000.00	6,604,130.00	17,895,870.00	27.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,989,000.00	-	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	445,000,000.00	18,644,236.02	426,355,763.98	4.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,951,500.00	47,874,321.00	6,077,179.00	88.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,088,101.00	(1,088,101.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	128	122	6	95.3
620001	Удирдах ажилтан	11	11	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	66	53	13	80.3
620003	Үйлчлэх ажилтан	51	58	(7)	113.7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	128	122	6	95.3
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	66	53	13	80.3
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	11	8	3	72.7
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	40	50	(10)	125.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	6	1	85.7
650012	Шүүгч, прокурор	4	5	(1)	125.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	-	<b>15,610,280.75</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>15,610,280.75</b>
122	Тусламжийн орлого	-	15,610,280.75
1221	Хандив тусламж /дотоод/	-	15,610,280.75
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,610,280.75
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,462,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,148,280.75
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>2,041,875.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>2,041,875.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	-	<b>2,041,875.00</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	1,815,000.00
210101	Үндсэн цалин	-	1,815,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	226,875.00
210201	Тэтгэврийн даатгал	-	226,875.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	-	<b>13,568,405.75</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>(13,568,405.75)</b>
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(13,568,405.75)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба нь шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүгчийн эрх ашгийг хамгаалах, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, шүүгчийн бие даан ажиллах нөхцөлийг хангах чиг үүрэгтэй, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 78 дугаар зүйлд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Ерөнхий зөвлөлийн гишүүнд үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлэх, Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах;
- Гүйцэтгэх нарийн бичгийн дарга ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;
- Ерөнхий зөвлөл батлагдсан төсвийн хүрээнд ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоог тогтоох;
- Ерөнхий зөвлөлийн ажлын алба нь чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн нэгжээс бүрдэх;
- Ерөнхий зөвлөлийн дэргэд иргэний болон захиргааны хэргийн тусгай архив ажиллах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Шүүхийн тухай хууль, Шүүх байгуулах тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 тоот тогтоолоор “Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр Төрийн худалдан авах ажиллагааны газраас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 1 дүгээр хавсралт, “Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгөөр аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг 2 дугаар хавсралтаар баталсан;
- Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг баталсан;

- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” 133 дугаар тогтоол;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын ажлыг хууль, журмын дагуу бүрэн хэрэгжүүлж, батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хугацаанд нь зохион байгуулж байх талаар зөвлөмж өгсөн.

Тайлант онд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар шүүхийн бие даасан байдлыг хангах, мэдээллийн технологи инновацыг ашиглан шүүх, шүүхийн захиргааны үйл ажиллагааны цахим шилжилтийн түвшнийг нэмэгдүүлэх, шүүхийн хүний нөөцийн менежментийг сайжруулах, бодлого хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хүрэлцээг нэмэгдүүлэх гэсэн 3 зорилтын хүрээнд 20 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэн батлах тухай” 215 дугаар

тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр боловсруулан мөрдөж байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,158,357.6 мянган төгрөгөөр буюу 97.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,088.1	-	(1,088.1)
Авлага	-	1,968.5	1,968.5
Урьдчилгаа	9,539.6	9,401.0	(138.6)
Бараа материал	397,113.2	382,533.3	(14,579.9)
Үндсэн хөрөнгө	13,160,915.3	26,333,111.0	13,172,195.7
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>13,568,656.2</b>	<b>26,727,013.8</b>	<b>13,158,357.6</b>
Өр төлбөр	2,530.9	-	(2,530.9)
Засгийн газрын оруулсан капитал	2,646,495.1	2,646,495.1	-
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>8,275,326.2</b>	<b>21,466,916.6</b>	13,191,590.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,644,304.0	2,613,602.1	(30,701.9)
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>13,568,656.2</b>	<b>26,727,013.8</b>	<b>13,158,357.6</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Тухайлбал:

- Авлага дансны үлдэгдэл 1,968.5 мянган төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 880.4 мянган төгрөг болон татаас, 1,088.1 мянган төгрөгийг санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 26,333,111.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,172,195.7 мянган төгрөгөөр өссөн нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 14,476,982.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авч, 68,860.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Хууль зүй дотоод хэргийн яамнаас 95,363.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, ТӨБЗГ-аас хөрөнгийг дахин үнэлүүлж 177,628.6 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч, нийт 14,818,835.3 мянган төгрөгөөр нэмэгдэж 340,935.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 237,626.8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, 393,679.0 мянган төгрөгийг дахин үнэлүүлэхээр данснаас хасаж, хуримтлагдсан элэгдлийн бууралт 854,357.0 мянган төгрөг тайлант онд 1,528,755.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсантай тус тус холбоотой.
- Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 21,466,916.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,191,590.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны 13,160,888.5 мянган төгрөгийн үр дүн болон 30,701.9 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийн залруулгатай холбоотой байна.

**Судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тус ажлын албаны санхүүгийн тайланд 2018-2024 онд ашиглалтад орсон шүүгчийн сонгон шалгаруулалтын программ, шүүхийн захиргааны цахим сургалтын систем, хүний нөөц болон санхүүгийн нийт 18 нэр төрлийн программ хангамжийг хэвийн ашиглаж байна;
- Мөн тайлант хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 10,970,953.0 мянган төгрөгийн “Цахим шүүх 2.0” цөм систем, программ хангамжийг шилжүүлэн хүлээн авч, санхүүгийн тайланд тусгасан байна;
- Тухайн “Цахим шүүх 2.0” цөм системийг нэвтрүүлснээр шүүх болон шүүхийн захиргааны үйл ажиллагаанд инновац, мэдээллийн технологид суурилсан үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрүүд нэвтэрч, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангагдаж үйл ажиллагаа цаасан сууринаас цахим хэлбэрт шилжиж, ажлын бүтээмж, үр дүнг бодитой хэмжих боломж бүрдэн, шүүх эрх мэдлийн байгууллагын төсвийн үр ашиг дээшилж, авлигын индексэд эерэг нөлөө үзүүлэх нөхцөл бүрдсэн байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 13,855,881.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 510,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал засварын зардлыг 13,955,881.2 мянган төгрөгөөр өсгөж баталсан байна. Энэ нь эд хогшил, урсгал засварын зардлыг 100,000.0 мянган төгрөгөөр өсгөсөн нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн байрны урсгал засварын ажил хийхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг тодотголоор цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 786,475.5 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 98,309.5 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 58,803.0 мянган төгрөгөөр, нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 78,749.7 мянган төгрөгөөр бууруулж, байр ашиглалтай холбоотой тогтмол зардлыг 93,743.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 135,819.3 мянган төгрөгөөр, нормативт зардал 4,968.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардал 124,635.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 103,935.9 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлэг 490,840.5 мянган төгрөгөөр өсгөж, нийт зардлыг 13,887,486.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 68,394.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Хүснэгт 2. Төсвийн төлөвлөлт

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	2025 оны төсөв			Зөрүү
		ТЕЗ-д анх хүргүүлсэн санал	Анх батлагдсан төсөв	Тодотголоор батлагдсан төсөв	Дүн
1	2	3	4	5	6=5-4
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	10,065,160.0	10,065,160.0	9,278,684.5	(786,475.5)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,258,145.0	1,258,145.0	1,159,835.5	(98,309.5)
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	460,000.0	460,000.0	553,743.6	93,743.6
2104	Хангамж, бараа материалын зардал	345,000.0	345,000.0	480,819.3	135,819.3
2105	Норматив зардал	8,000.0	8,000.0	12,968.4	4,968.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	390,000.0	490,000.0	431,197.0	(58,803.0)
2107	Томилолт, зочны зардал	250,000.0	250,000.0	374,635.7	124,635.7
2108	Нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	693,976.2	693,976.2	615,226.5	(78,749.7)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	350,000.0	350,000.0	453,935.9	103,935.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,600.0	35,600.0	526,440.5	490,840.5
22	Хөрөнгийн зардал	-	-	-	-
<b>Нийт зардал</b>		<b>13,855,881.2</b>	<b>13,955,881.2</b>	<b>13,887,486.9</b>	<b>(68,394.3)</b>

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээнд улсын төсвөөс 13,887,486.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 510,000.0 мянган төгрөгийг бүрдүүлж зарцуулахаар батлагдсан байна.

Гүйцэтгэлээр улын төсвөөс 11,747,952.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, 156,145.9 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого бүрдүүлэн, 11,460,214.0 мянган төгрөгийг зарцуулж, 443,884.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70701	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах	13,887,486.9	11,460,214.0	2,427,272.9	82.5
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	13,200,401.2	11,387,091.3	1,813,309.9	86.3
80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад	2,989.0	-	2,989.0	-
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	523,451.5	73,122.7	450,328.8	14.0

81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	160,645.2	-	160,645.2	-
-------	---	-----------	---	-----------	---

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Бусад судалгааны үр дүн:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2024 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/44 дугаар тушаалаар нэг ажилтанд ногдох 1 өдрийн хоолны тариф 32.0 мянган төгрөг, унааны 3.0 мянган төгрөгөөр баталсан байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөв 1,169,740.4 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 1,169,661.3 мянган төгрөг зарцуулсан байна;
- Гадаад томилолтын зардлын төсөв 145,745.8 мянган төгрөгөөр батлагдаж, Гэр бүл, хүүхдийн хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс байгуулахтай холбогдуулан Австралийн Холбооны Улсын Гэр бүлийн шүүхийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлан 128,214.1 мянган төгрөгийг зарцуулсан байна;
- Шүүхийн тухай хуульд заасны дагуу сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн сургалт зохион байгуулж, гүйцэтгэлээр 125,236.8 мянган төгрөгийн зардлыг зарцуулсан байна;
- Тайлант онд шүүхийн нээлттэй, ил тод байдлыг хангах, шүүхийн мэдээллийг олон нийтэд тухай бүр хүргэх, Монгол Улсын Шүүхийн тухай хууль болон шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлогыг сурталчлах, мэдээлэл түгээх, иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Ханбан трэйд эйнд деволоп ХХК, Засгийн мэдээ ХХК, Бенекрафт ХХК, Улаанбаатар ньус ХХК, Эм жи эл радио ньус ХХК, Өглөөний сонин паблишинг ХХК нартай гэрээ байгуулж, 28,500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Архивын ерөнхий газраас архив хариуцсан гэрээт ажилтны цалингийн 15,610.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2,041.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13,568.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төсвийн ерөнхийлөн захирагч нэгтгэн зохион байгуулсан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 20,836,890.0 мянган төгрөгийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 1,118,270.0 мянган төгрөгийг харьцуулалтын аргаар худалдан авалт хийхээр төсөвлөснөөс, гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтаар 10,885,466.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 910,703.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Үүнээс шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны хэрэгцээнд шатах, тослох материалыг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Шунхлай трейдинг” ХХК шалгарч, гүйцэтгэлээр 53,315.0 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Батхишиг гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/136 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 9,498,670.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 94,986.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор бичиг хэргийн зардлын нэг хүнд ногдох хэмжээ 1,677.9 мянган төгрөг байснаас 925.8 мянган төгрөгөөр бууруулах арга хэмжээ авч ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөрчлийг арилгах 1 албан шаардлага, давтан гаргахгүй анхаарч ажиллах 1 зөвлөмж өгсөн.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 135 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан төсөв болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,325.1 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10 “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.4.4 “мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Илрүүлэлт: Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11 тоот тушаалаар баталсан “Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 1.9.8-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албанд аудит хийнэ” гэж төлөвлөсөн боловч тайлант онд хяналт, шалгалтыг хийгээгүй байна.

Энэ нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8 “шүүхийн Тамгын газар, шүүхийн тусгай архивт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, 74 дүгээр зүйлийн 74.1.5.Улсын дээд шүүхээс бусад шүүхийн санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн ажлыг зохион

байгуулж, хянан шалгаж, удирдах, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх журам”-ын 4.3.1 “Нэгж нь Тамгын газрын үйл ажиллагаанд цахимаар адит хийж, дүнг Ерөнхий зөвлөлийн даргад танилцуулж, Ерөнхий зөвлөлд тайлагнана” гэсэн заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хяналт-шинжилгээ, дотоод аудитын ажлыг хууль, журмын дагуу бүрэн хэрэгжүүлж, батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу хугацаанд нь зохион байгуулж байх талаар зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны II улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, зардлын дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар нийт 814,825.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 34,490.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, 780,335.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 2 зөвлөмж хүргүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлага, 136,950.5 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөг/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	4	136,950.5	4	136,950.5	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>136,950.5</b>	<b>5</b>	<b>136,950.5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын удирдамжийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга баталдаг боловч тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг ажлын албаны гүйцэтгэх нарийн бичгийн дарга баталж, үнэлдэг бөгөөд чиг үүргийн хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлд, бүтэц, зохион байгуулалтын хувьд ажлын албанд харьяалагдаж байна.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2024 оны А/85 дугаар тушаалаар ажлын албаны бүтэц, орон тоог 162 албан хаагчдтай баталсан бөгөөд тайлант онд 115 албан хаагчтай байна. Төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах бодлогын хүрээнд төрийн албан хаагчдын орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ажлын албаны бүтэц, орон тоог төсвийн ерөнхийлөн захирагч дотооддоо хэрхэн зохион байгуулсан талаар дараагийн шатны аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.
- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем” дэх тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 145,198.0 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 145,198.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Тайлант онд хувь хүний орлогын албан татварын 2,530.9 мянган төгрөгийн өглөгийг илүү бүтгэсэн;
- Ахмадын сангийн үлдэгдэл төвлөрүүлсэн 1,088.1 мянган төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг санхүүгийн тайланд толилуулаагүй орхигдуулсан;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 34 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоож, 141,579.0 мянган төгрөгөөр шинэ хөрөнгө хүлээн зөвшөөрөхдөө орлогоор бүртгээгүй байгаа зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Аудитаар нийт 156,802.1 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2,252.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 154,549.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар илэрсэн 156,802.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 94,986.7 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

#### 5.1.1. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын данстай холбоотой

Илрүүлэлт: Тайлант оны 5 дугаар сард төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь үндсэн албан тушаалаас чөлөөлөгдсөн боловч тухайн ажилтанд салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалд хамаарах 5 сарын урамшуулалд 2,252.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 “Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 233 дугаар тогтоол “Салбар зөвлөлийн гишүүнээр томилох тухай” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан тушаалаасаа чөлөөлөгдсөн ажилтанд илүү олгосон 2,252.6 мянган төгрөгийн урамшууллыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **5.2.1. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг нарийвчлан төлөвлөөгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 11 бараа, ажил, үйлчилгээг 149,829.5 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3 "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### **5.1.2. Зардлын данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж бэлэг, дурсгалын зүйлсэд 4,720.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, 15 дугаар зүйлийн 15.1.5 “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж бэлэг, дурсгалын зүйлс худалдан авч, үр ашиггүй зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

### 5.3 Зөвлөмж

#### 5.3.1 Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгын тайлбар, тэмдэглэлийг үйлдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3 "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайлангийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан тодруулга тайланг гаргаж байх талаар зөвлөмж өгөв.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд хувь хүний орлогын албан татварын 2,530.9 мянган төгрөгийн өглөгийг илүү тайлагнасан байна.	1	2,530.9	-	-	1	2,530.9	1	2,530.9	-	-	-	-
Ахмадын сангийн үлдэгдэл төвлөрүүлсэн 1,088.1 мянган төгрөгийн татаас, санхүүжилтийн авлагыг санхүүгийн тайланд толилуулаагүй орхигдуулсан байна.	1	1,088.1	1	1,088.1	-	-	1	1,088.1	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 34 нэр төрлийн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоож, 141,579.0 мянган төгрөгөөр шинэ хөрөнгө хүлээн зөвшөөрч бүртгэхдээ бусад орлого дансанд бүртгээгүй байна.	1	141,579.0	-	-	1	141,579.0	1	141,579.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>145,198.0</b>	<b>1</b>	<b>1,088.1</b>	<b>2</b>	<b>144,109.9</b>	<b>3</b>	<b>145,198.0</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөг/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу санхүүгийн тайлангийн тодруулгын тайлбар, тэмдэглэлийг үйлдээгүй байна	1	-	-	-	-	-	1	-
Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж бэлэг, дурсгалын зүйлсэд 4,720.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	4,720.0	-	-	1	4,720.0	-	-
Тайлант онд батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 11 бараа, ажил, үйлчилгээг 149,829.5 мянган төгрөгөөр худалдан авсан байна.	1	149,829.5	-	-	1	149,829.5	-	-
Тайлант оны 5 дугаар сард төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн боловч тухайн ажилтанд салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалд хамаарах 5 сарын урамшуулал нийт 2,252.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	2,252.6	1	2,252.6	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>156,802.1</b>	<b>1</b>	<b>2,252.6</b>	<b>2</b>	<b>154,549.5</b>	<b>1</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11 тоот тушаалаар баталсан " Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний 1.9. Хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх чиглэлээр 1.9.8 "Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын албанд аудит хийнэ" гэж төлөвлөсөн боловч тайлант онд хяналт, шалгалтыг хийгээгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан төсөв болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,325.1 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	10,325.1	-	-	1	10,325.1	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>10,325.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>10,325.1</b>	<b>1</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 08/АМ 75177

Улаанбаатар хот

САГ-2026/327/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж бэлэг, дурсгалын зүйлсэд 4,720,000.00 /Дөрвөн сая долоо зуун хорин мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.3 "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6 "төсвийг зориулалт бусаар зарцуулсан"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж бэлэг, дурсгалын зүйлс худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтулга/, ахлах нягтлан бодогч /С.Оюунаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Э.БАТ-ЭРДЭНЭ  
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 06/АО 175177

Улаанбаатар хот

САГ-2026/327/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан төсөв болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,325,100.00 /Арван сая гурван зуун хорин таван мянга нэг зуун/ төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10 "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 7 дугаар зүйлийн 7.4.4 "мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтулга/, ахлах нягтлан бодогч /С.Оюунаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Н*  
АУДИТЫН МЕНЕЖЕР *С.О* Ц.НАРАНЧИМЭГ  
АХЛАХ АУДИТОР *С.О* С.НАЦАГДОРЖ  
АУДИТОР *С.О* Э.БАТ-ЭРДЭНЭ  
Б.БАТХИШИГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 07/A0175177

Улаанбаатар хот

САГ-2026/327/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөөгүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 11 бараа, ажил, үйлчилгээг 149,829,541.00 /Зуун дөчин есөн сая найман зуун хорин есөн мянга таван зуун дөчин нэгэн/ төгрөгөөр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.3 "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар бүлгийн 2.2 "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн, дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтулга/, ахлах нягтлан бодогч /С.Оюунаа/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Э.БАТ-ЭРДЭНЭ  
Б.БАТХИШИГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 03/A017-5177

Улаанбаатар хот

САГ-2026/327/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 5 дугаар сард төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн боловч тухайн ажилтанд салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан тушаалд хамаарах 5 сарын урамшуулал нийт 2,252,631.58 /хоёр сая хоёр зуун тавин хоёр мянга зургаан зуун гучин нэгэн/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 233 дугаар тогтоол "Салбар зөвлөлийн гишүүнээр томилох тухай" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан тушаалаасаа чөлөөлөгдсөн ажилтанд илүү олгосон 2,252,631.58 /хоёр сая хоёр зуун тавин хоёр мянга зургаан зуун гучин нэгэн/ төгрөгийн урамшууллыг Шүүхийн захиргааны хүний нөөцийн дарга Б.Оюуннасангаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 дугаар дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэтулга/, ахлах нягтлан бодогч /С.Оюунаа/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Н. Р. В.*  
АУДИТЫН МЕНЕЖЕР *С. О.*  
АХЛАХ АУДИТОР *Б. Т. Н.*  
АУДИТОР *Б. Т. Н.*

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Э.БАТ-ЭРДЭНЭ  
Б.БАТХИШИГ

9026189  
ATA18007  
9025081411